

**ОЛОН УЛСЫН ВИЗА КАРТ ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН
ЭМНЭЛГИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР
(Visa Mongolia Medical Program)**

2016 оноос эхлэн Виза компани нь эмчилгээний албан ёсны төлөөлөгч Openbay ХХК-тай хамтран Монголын олон улсын виза карт хэрэглэгч үйлчлүүлэгчиддээ зориулан “Visa Mongolia Medical Program”-г хэрэгжүүлж байна. Монголоос олон улсын виза карт эзэмшиж байгаа үйлчлүүлэгч БНСУ-ын шилдэг эмнэлэгүүдэд чанартай үйлчилгээ авах ба виза карттай хамтарч ажилладаг байгууллагуудын онцгой хөнгөлөлтүүдийг эдлэх боломжтой.

“Монгол дах виза картын консьержи оффис”-руу залган Солонгос эмнэлэгүүдийн захиалга болон виза картын хөнгөлөлтийн талаар дэлгэрэнгүй зөвлөгөө авна уу.

- ✓ Эмчилгээгээ хийлгээд 20 хүртэлх хувийн хөнгөлөлт эдлэх боломжтой.
- ✓ Энэхүү хөтөлбөр нь 2018 оны 12-р сарын 31-ны өдрийг хүртэл хэрэгжинэ.
- ✓ Монгол дах виза картын консьержи оффис:
 - Phone: 976 7711 1400 (Монгол хэлээр зөвлөгөө авах боломжтой)
 - E-mail: help@openbay.kr

Харилцагч эмнэлэгүүдээс эдлэх хөнгөлөлтийн хэмжээ

НЭГДСЭН ЭМНЭЛЭГ	Эрүүл мэндийн урьдчилсан шинжилгээ	Seoul St. Mary’s Hospital 5% Cheil Hospital 15% Korea University Anam Hospital 20%
	Хэвтэн эмчлүүлэх эмчилгээ	Korea University Anam Hospital 3% Gangnam Severance Hospital 3% Seoul Asan Hospital 3% Bundan Cha Hospital 3%
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМНЭЛЭГ	Хэвтэн эмчлүүлэх эмчилгээ	Gangnam Cha Hospital 3%
ХӨГШРӨЛТИЙН ЭСРЭГ ТӨВ	Эрүүл мэндийн урьдчилсан шинжилгээ	Chaum Anti-Aging Hospital 5%

ЧИХ, ХАМАР, ХООЛОЙ	Мэс засал	HANA ENT 5%
НҮД	Мэс засал	Seoul/Busan BalGeunSeSang Eye Clinic 5%
ШҮД	Мэс ажилбар	Today Dental Clinic 10%
ГОО САЙХНЫ МЭС ЗАСАЛ	Мэс ажилбар	Face Line Plastic Surgery 10%

Нөхцөл :

1. Хөтөлбөр нь 2017 оны 06-р сарын 1-ны өдрөөс 2018 оны 12-р сарын 31-ны өдрийг хүртэл хэрэгжинэ.
2. Та Виза картны консьержи оффисоор дамжуулан захиалга өгөх бөгөөд өөр байгууллагаар захиалга өгсөн тохиолдолд хөнгөлөлт эдлэх боломжгүй.
3. Монголоос авсан олон улсын виза карт (зээлийн карт болон чек)-р хязгаарлагдах бөгөөд виза картаар төлбөрөө хийсэн тохиолдолд хөнгөлөлт эдлэх боломжтой. Бусад төрлийн карт эсвэл бэлэн мөнгөөр төлбөрөө хийсэн тохиолдолд хөнгөлөлт эдлэх боломжгүй.
4. Эмнэлгийн зүгээс үзүүлж буй өөр төрлийн хөнгөлөлт болон урамшуулалд хамрагдсан тохиолдолд хөнгөлөлт эдлэх боломжгүй.
5. Эмчилгээгээ хийлгэж дууссаны дараа эцсийн байдлаар төлбөрөө хийх үедээ хөнгөлөлт эдлэх боломжтой. Харин нэгдсэн эмнэлгийн тохиолдолд үйлчлүүлэгч эмчилгээгээ дуусгаж төлбөрөө хийх ба виза картаар хийсэн төлбөрөөс хөнгөлөлтийн хувийг тооцон татвар суутгасны дараа буцаан олголт хийнэ. Буцаан олголт хийхдээ хэрэглэгчийн өөрийн хувийн дансруу шилжүүлнэ.
6. Эмчилгээтэй холбоотой бүхий л хариуцлагыг эмнэлэг хариуцах ба эмнэлэг болон өвчтөний хооронд үүссэн маргаан үүссэн тохиолдолд виза карт болон зуучлагч Openbay компани хариуцлага хүлээхгүй болно.

Үйлчлүүлэх заавар :

Виза картын эмчилгээний албан ёсны төлөөлөгч Openbay компани нь Монгол дах консьержи оффистой бөгөөд “Visa Mongolia Medical Program”-н талаар танилцуулга, эмнэлэгт үйлчлүүлэх цагийн захиалга, хөтөлбөртэй холбоотой бүхий л зөвлөгөө, мэдээллийг та бүхэн утсаар авах боломжтой.

Цагийн хуваарь : Даваа – Баасан гараг 09:00 – 18:00 цаг

(Амралтын өдөр болон олон нийтийн амралтын өдөр амарна.)

Step 1 | Зөвлөгөө

Монгол дах виза картын консьержи оффистой холбогдон сонирхож буй эмнэлэг, эмчилгээ хийлгэх хугацаа зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

Step 2 | Төлбөр төлөх

Монгол дах виза картын консьержи оффис нь Солонгосын эмнэлэгтэй холбогдон үйлчлүүлэгчийн хүссэн нөхцөлд зохицох хамгийн сайн эмнэлэгт цаг захиалах, эмчилгээний төлбөрийн талаарх анхан шатны мэдээлэл өгнө.

Step 3 | Хөтөлбөр

Солонгосын эмнэлэгт цаг авсан тохиолдолд Монгол дах виза картын консьержи оффис нь захиалгын хуудсыг авч үйлчлүүлэгчидэд дамжуулан өгнө. Үйлчлүүлэгч тухайн захиалгын хуудсыг авсны дараа эмчилгээний болон аяллын виз мэдүүлэн аяллын хөтөлбөр гаргасны дараа Монгол дах виза картын консьержи оффисоор дамжуулан эмнэлгийн захиалгын цагийг дахин нягтална.

Step 4 | Бүртгүүлэх

Үйлчлүүлэгч нь эмнэлгээс захиалга цуцлахаас 1 хоногийн өмнө БНСУ-д ирсэн байх ба БНСУ-д очсоны дараа картын консьержи оффисд БНСУ-д холбоо барих утасны дугаарыг өгнө. Эмнэлгийн захиалгат цагаас 20 минутын өмнө орчуулагчтай уулзан бүртгүүлж, эмчтэй уулзах хэрэгтэй. Тухайн үедээ Монголд үзүүлсэн CD бичлэг болон оношын бичгээ англи хэл дээр авчирвал зөвлөгөө хурдан хугацаанд, оновчтой явагдах боломжтой.

Step 5 | Шинжилгээ хийлгэх, эмнэлэгт хэвтэх

Зөвлөгөө авсны дараа шаардлагатай шинжилгээ хийлгэн эмнэлэгт хэвтэх шаардлагатай бол хэвтэн эмчлүүлнэ.

Step 6 | Эмнэлгээс гарах

Эмчилгээ дууссаны дараа эмчийн зөвшөөрөлтэйгээр эмнэлгээс гарна. Эмнэлгээс гарах тохиолдолд үйлчлүүлэгч төлбөрөө төлөх ба олон улсын виза картаар хийсэн төлбөрөөс хөнгөлөлтийн хувийг тооцон татвар суутгасны дараа буцаан олголт хийнэ. Буцаан олголт хийхэд хэрэглэгчийн хувийн дансруу шилжүүлнэ.

Step 7 | Эмчилгээний дараах арчилгаа

Монголруу буцсаны дараа ч гэсэн Монгол дах олон улсын виза картын консьержи оффисоор дамжуулан эмчилгээний дараах зөвлөмжийг авах бөгөөд давтан эмчилгээний захиалга болон бусад мэдээллийг авах боломжтой.